



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 06 сарын 13 өдөр

Дугаар А/481

Булган сум

**Гүйцэтгэгчид гэрээ байгуулах
эрх олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн XIII/21 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан Сумын төвийн цахилгаан хангамжийн 0.4-10 кв-ын ЦДАШ-ын шинэчлэл (Баяннуур сум)-ийн ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хорооны 2023 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн хурлын зөвлөмжийн дагуу гүйцэтгэгчээр шалгарсан "Цац эрчис" ХХК-тай 257 246 424 /Хоёр зуун тавин долоон сая хоёр зуун дөчин зургаан мянга дөрвөн зуун хорин дөрөв/ төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т олгосугай.

2. Гүйцэтгэж буй ажилд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т үүрэг болгосугай.

3. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль тогтоомж, стандарт, зураг, төсвийн дагуу гүйцэтгэж хүлээлгэн өгөхийг "Цац эрчис" ХХК-ийн захирал (Э.Мөнгөнбосго)-д даалгасугай.

4. Тус ажлыг хууль, журам, гэрээний дагуу Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Батцогт)-т зөвшөөрсүгэй.

5. Хавсралтад заагдсан үзүүлэлтүүдийг гэрээнд тусгаж, хяналт тавин ажиллахыг холбогдох байгууллагын дарга нарт даалгасугай.


ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

6323010478

Аймгийн Засаг даргын 2023 оны 06... сарын
13. өдрийн А/487 дугаар захирамжийн хавсралт



№	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	Магадлашгүй ажил	4,466,859	Ү.Бямбасүрэн
2	Захиалагчийн албаны зардал	4,466,859	Ү.Бямбасүрэн
3	Зураг төсөв зохиогчийн хяналтын зардал	2,233,430	Ү.Бямбасүрэн
4	Инженер хайгуул зураг төслийн ажлын дүн	0	Ү.Бямбасүрэн
5	Алданги	Хоногт гэрээний үнийн 0.05 хувь, нийт алданги гэрээний үнийн 10 хувиас хэтрэхгүй байна.	Д.Батцогт
6	Ажил гүйцэтгэх хугацаа	90 хоног	Ү.Бямбасүрэн
7	Гүйцэтгэлийн баталгаанй дүн	Гэрээний үнийн дүнгийн 3 хувь.	Д.Батцогт